



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 1/232

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам"-ын 3.6.1, 3.6.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2024 оны төсвийн тодотгол батлах тухай" 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолын 8 дугаар хавсралтын 3, 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийн хог байгальд тархахаас сэргийлэх ажлын зардалд 6,000,000 (зургаан сая), төгрөг, нэн ховор, ховор амьтдад биотехикийн арга хэмжээний зардалд 7,275,000 (долоон сая хоёр зуун далан таван мянга) төгрөг, нийт 13,275,000 (арван гурван сая хоёр зуун далан таван мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийн хог байгальд тархахаас сэргийлэх ажлын зардлын тооцоог 1 дүгээр хавсралтаар, нэн ховор, ховор амьтдад биотехикийн арга хэмжээний зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Зардалд шаардагдах 13,275,000 (арван гурван сая хоёр зуун далан таван мянга) төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ



Сумын Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 28-ны өдрийн А/232
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт




ХӨРСНИЙ ДОРОЙТЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР
ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ХОГ БАЙГАЛЬД ТАРХАХААС
СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийг байгальд тархахаас сэргийлэх шатахууны зардал	1500	3,590	5,385,000
2	Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төвлөрсөн хогийн цэгийг байгальд тархахаас сэргийлэх тос, маслын зардал	41	15000	615,000
3	Нийт дүн			6,000,000

---oOo---

Сумын Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 28-ны өдрийн А/232
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАНД БИОТЕХНИКИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Нэн ховор, ховор амьтанд тавьж өгөх нарийн ногоон өвс	350	16,000	5,600,000
2	Нэн ховор, ховор амьтанд тавьж өгөх хужир, давс бусад зардал	335	5000	1,675,000
3	Нийт дүн			7,275,000

---oOo---